

ХҮН АМЫН ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАЛ

Дундговь аймгийн нутаг дэвсгэрт оршин суугаа хүн амын 99.95 хувь нь Монгол Улсын харьяат, 0.05 хувь нь гадаадын харьяат иргэн байна. Дундговь аймгийн нутаг дэвсгэрт оршин суугаа хүн амын тоо 46 698 боллоо. Тус аймагт 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин сууж байгаа иргэдийн тоо 2010 оноос 17.9 хувиар буурсан байна.

ЗУРАГ 3.1. ХҮН АМЫН ТОО, ИРГЭНИЙ ХАРЬЯАЛЛААР, 2020 ОН



ХҮСНЭГТ 3.1. ДУНДГОВЬ АЙМГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ ОРШИН СУУГАА ХҮН АМЫН ТОО, СУМД, ХҮЙС, ХҮЙСИЙН ХАРЬЦАА, 2010, 2020 ОН

Дүүрэг	2010			2020			Хүйсийн харьцаа	
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	2010	2020
БҮГД	38 543	19 578	18 965	47 104	23 669	23 435	103.2	101.0
Дэлгэрцогт	1 166	610	556	1 652	867	785	109.7	110.4
Дэрэн	1 481	759	722	2 162	1 110	1 052	105.1	105.5
Говь-Угтаал	1 312	682	630	1 550	812	738	108.3	110.0
Цагаандэлгэр	674	353	321	1 055	554	501	110.0	110.6
Баянжаргалан	1 135	625	510	1 306	685	621	122.5	110.3
Өндөршил	1 433	740	693	1 415	692	723	106.8	95.7
Гурвансайхан	1 676	854	822	2 144	1 085	1 059	103.9	102.5
Өлзийт	1 757	930	827	2 395	1 308	1 087	112.5	120.3
Хулд	1 623	804	819	2 399	1 233	1 166	98.2	105.7
Луус	1 369	721	648	1 889	981	908	111.3	108.0
Дэлгэрхангай	1 894	945	949	2 316	1 177	1 139	99.6	103.3
Сайхан-Овоо	1 904	996	908	2 148	1 111	1 037	109.7	107.1
Эрдэнэдалай	5 097	2 558	2 539	5 872	2 974	2 898	100.7	102.6
Сайнцагаан	13 664	6 787	6 877	15 957	7 623	8 334	98.7	91.5
Адаацаг	2 358	1 214	1 144	2 844	1 457	1 387	106.1	105.0

ХҮН АМЫН ҮНДЭС, УГСАА

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогоор Монгол Улсын харьяат иргэдийн үндэс, угсааны талаарх мэдээллийг нилээн өргөжүүлэн судаллаа. Тооллогын үр дүнгийн танилцуулгад бүлэгт 5-аас цөөн хүн амтай үндэс, угсааны бүлгийг “Бусад” гэж нэгтгэсэн болно.

Дундговь аймгийн суурин хүн амын 99.6 хувийг Халхчууд эзэлж байгаа нь өмнөх тооллогоос 0.2 пунктээр буурсан байна. Бусад угсаатнууд нийт дүнгээр 0.4 хувийг эзэлж байна. Үүнд: Дөрвөд угсаатан 48, Баяд 33, Буриад 30, бусад угсаатан 80 хүн байна.

ХҮСНЭГТ 3.2. ХҮН АМЫН ТОО, ҮНДЭС УГСАА, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН

¹ Гадаадад оршин суугаа Монгол Улсын иргэдийн тоо ороогүй

Үндэс угсаа	2010		2020	
	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Хүний тоо	Дүнд эзлэх хувь
ДУНДГОВЬ АЙМГИЙН-БҮГД¹	38 515	100.0	46 675	100.0
Халх	38 439	99.80	46 484	99.59
Казах	2	0.01	7	0.01
Дөрвөд	16	0.04	48	0.10
Буриад	9	0.02	30	0.06
Баяд	8	0.02	33	0.07
Дарьганга	-	0.00	15	0.03
Урианхай	3	0.01	8	0.02
Захчин	6	0.02	8	0.02
Дархад	3	0.01	8	0.02
Өөлд	12	0.03	15	0.03
Бусад	11	0.03	19	0.04

Хүн амын үндэс угсааг насны бүтцээр судлах нь тухайн үндэс угсаатны цаашид өсөх, буурах талаар хамгийн эхний таамаглал дэвшүүлэх боломж олгодог. Хүн амын үндэс угсааг насны бүлгээр авч үзвэл Дархад, Буриад, Баяд, Урианхай ястны дунд 0-14 насныхан хамгийн өндөр буюу 50-33.3 хувь эзэлж байна. Харин хүн амын 99.6 хувийг эзэлж байгаа Халхчуудын 30.3 хувийг 0-14 насныхан эзэлж байна.

ХҮСНЭГТ 3.3. ХҮН АМЫН ҮНДЭС, УГСАА, НАСНЫ БҮЛЭГ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН

Үндэс угсаа	Насны бүлэг						
	Бүгд	0-14	15-24	25-34	35-44	45-54	55+
МОНГОЛ УЛСЫН ХАРЬЯАТ-БҮГД	100	30.3	16.1	14.9	14.0	11.2	13.5
Халх	100.0	30.3	16.1	14.9	14.0	11.2	13.5
Казах	100.0	0.0	28.6	14.3	14.3	0.0	42.9
Дөрвөд	100.0	25.0	10.4	16.7	12.5	29.2	6.3
Буриад	100.0	33.3	6.7	26.7	10.0	6.7	16.7
Баяд	100.0	33.3	6.1	27.3	9.1	15.2	9.1
Дарьганга	100.0	20.0	6.7	40.0	26.7	6.7	0.0
Урианхай	100.0	37.5	0.0	12.5	12.5	25.0	12.5
Захчин	100.0	12.5	0.0	37.5	25.0	25.0	0.0
Дархад	100.0	50.0	0.0	50.0	0.0	0.0	0.0
Өөлд	100.0	33.3	6.7	20.0	20.0	20.0	0.0
Бусад	100.0	31.6	10.5	15.8	10.5	15.8	15.8

ЗУРАГ 3.2. ХҮН АМ, ҮНДЭС, УГСАА, ХУВИАР, 2020 ОН

ХАЛХ
99.6%



ДӨРВӨД
0.1%



БАЯД
0.07%




БУРИАД
0.06%



ГАДААДЫН ХАРЬЯАТ ИРГЭД

ЗУРАГ 3.3. ДУНДГОВЬ АЙМАГТ ОРШИН СУУГАА ГАДААДЫН ХАРЬЯАТ ИРГЭД, УЛСААР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН



Дундговь аймагт амьдарч байгаа гадаадын харьяат иргэд улсын дүнд 2010 онд 0.2 хувийг, 2020 онд 0.05 хувийг эзэлж байгаа бөгөөд гадаадын харьяат иргэдийн 95.7 хувь нь хөдөлмөрийн насны хүн ам, 65.2 хувь нь эрэгтэйчүүд байна.

ХҮСНЭГТ 3.4. ДУНДГОВЬ АЙМАГТ ОРШИН СУУГАА ГАДААДЫН ХАРЬЯАТ ИРГЭДИЙН ТОО, СУМ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР 2010, 2020 ОН

Сум	2010		2020	
	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Хүний тоо	Дүнд эзлэх хувь
БҮГД	28	100.0	22	100.0
Говь-Угтаал	6	21.4	3	13.6
Цагаандэлгэр	1	3.6	-	-
Баянжаргалан	15	53.6	3	13.6
Гурвансайхан	-	-	9	40.9
Өлзийт	2	7.1	-	-
Дэлгэрхангай	-	-	1	4.5

Сайнцагаан	4	14.3	6	27.4
------------	---	------	---	------

Дундговь аймагт амьдарч байгаа гадаадын харьяат иргэдийн 40.9 хувь нь Гурвансайхан, 27.4 хувь нь Сайнцагаан, 13.6 хувь нь Говь-Угтаал, Баянжаргалан сумдад тус тус амьдарч байгаа бөгөөд бусад сумдад гадаадын харьяат иргэн амьдардаггүй болно.

ХҮСНЭГТ 3.5. ДУНДГОВЬ АЙМГИЙН СУУРИН ХҮН АМ, ГАДААДЫН ХАРЬЯАТ ИРГЭДИЙН НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ, ХУВИАР, 2010, 2020 ОН

Насны бүлэг	Суурин хүн амын насны бүтэц	2010 Гадаадын харьяат иргэд			Суурин хүн амын насны бүтэц	2020 Гадаадын харьяат иргэд		
		Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй		Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
0-14	31.4	3.6	3.8	-	30.3	4.3	-	12.5
15-24	16.4	17.9	19.2	-	16.1	13	6.8	25
25-34	17.1	25	19.2	100.0	15.0	34.8	33.3	37.5
35-44	14.1	21.4	23.1	-	14.0	13	13.3	12.5
45-54	10.9	28.5	30.9	-	11.2	26.1	33.3	12.5
55+	10.1	3.6	3.8	-	13.5	8.8	13.3	-

Дундговь аймагт амьдарч байгаа гадаадын харьяат иргэдийг насны бүлгээр авч үзвэл эрчүүдийн хувьд 25-34, 45-54 насныхан 66.6 хувийг эзлэж байна. 2010 онд нийт гадаадын харьяат эмэгтэйчүүд бүгд 25-34 насныхан байсан бол 2020 оны тооллогын дүнгээр 25-34 насны эмэгтэйчүүд 37.5 хувийг эзлэж байна.

Тус аймагт оршин суугаа гадаадын харьяат 10, түүнээс дээш насны иргэдийг боловсролын түвшнээр нь авч үзвэл 25.0 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 25 хувь нь бүрэн дунд, 50 хувь нь бага боловсролтой иргэд байна.

Гадаадын харьяат иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар ангилбал 63.6 хувь нь үйлчилгээний бусад үйл ажиллагаа, 22.7 хувь нь олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа, 13.6 хувь нь уул уурхайн олборлолтын үйл ажиллагаа эрхэлж байна.

ЗУРАГ 3.4. ГАДААДЫН ХАРЬЯАТ ИРГЭДИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН



ШАШИН

Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн “Иргэний шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө” гэсэн 3 дугаар бүлгийн 1 дэх хэсэгт “аливаа шашныг шүтэх эс шүтэх нь тухайн хүний итгэл үнэмшлийн хэрэг байна” гэж заасан. Хүн ам орон сууцны тооллогод “Та шашин шүтдэг үү, шүтдэг бол ямар шашин шүтдэг вэ? гэсэн асуултыг анх удаагаа 2010 оны тооллогоор асууж байсан бөгөөд 2020 оны ээлжит тооллогод хүн амын 10 хувийн түүвэрт сонгогдсон 15, түүнээс дээш насны хүн амаас асуусан болно. Шашин шүтдэг хүмүүсийг хүйсээр авч үзвэл эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 5.9 пунктээр илүү шашин шүтдэг байна.

ХҮСНЭГТ 3.6. АРАВ БА ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ШАШИН ШҮТЛЭГИЙН БАЙДАЛ, ХҮЙС, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН

Шашин шүтлэгийн байдал	2010			2020		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Шүтдэггүй	35.1	40.1	29.9	30.7	33.8	27.9
Шүтдэг	64.9	59.9	70.1	69.3	66.2	72.1

Шашин шүтдэг хүмүүсийн 97.0 хувь нь Буддын шашинтан болох нь тооллогын дүнгээс харагдаж байна. Мөн 2010 онтой харьцуулахад нийт хүн амд Христийн шашинтны эзлэх хувь буурч, Бөөгийн шашинтны эзлэх хувь өссөн байна.

ХҮСНЭГТ 3.7. АРАВ БА ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ШАШИН ШҮТДЭГ ХҮН АМ, ШАШНЫ ТӨРӨЛ, ХҮЙС, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН

Шашны төрөл	2010			2020		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Будда	97.4	97.6	97.1	97.0	97.4	96.6
Христ	1.5	1.0	2.0	1.3	0.8	1.8
Ислам	-	-	-	0.0	0.1	0.0
Бөө	1.0	1.2	0.8	1.6	1.7	1.5
Бусад	0.1	0.2	0.1	0.1	0.0	0.1

Шашин шүтдэг нийт хүн амыг шашны төрөл болон насны бүлгээр авч үзвэл нас ахих тусам Буддын шашин шүтэж байхад Бөө мөргөлийн хувьд 20-29 насныхан, Христийн шашны хувьд 60-69 насныхан дийлэнх хувийг эзэлж байна.

ХҮСНЭГТ 3.8. АРАВ БА ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ШАШИН ШҮТДЭГ ХҮН АМ, ШАШНЫ ТӨРӨЛ, НАСНЫ БҮЛЭГ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН

Насны бүлэг	Шашинтан	Будда	Христ	Ислам	Бөө	Бусад
БҮГД	100.0	97.0	1.3	0.1	1.6	0.2
15-19	100.0	96.7	1.7	0.0	1.7	0.0
20-29	100.0	96.0	1.0	0.0	3.1	0.0
30-39	100.0	97.0	1.0	0.1	1.9	0.0
40-49	100.0	97.3	1.3	0.0	1.3	0.0
50-59	100.0	98.1	0.5	0.0	1.2	0.2
60-69	100.0	96.4	3.6	0.0	0.0	0.0
70+	100.0	98.2	1.8	0.0	0.0	0.0

15-19 насны шашин шүтдэг нийт хүний 96.7 хувь нь Буддын шашин шүтэж байхад 50-59 насныхны 98.1 хувь, 60-69 насныхны 96.4 хувь, 70 ба түүнээс дээш насныхны 98.2 хувь нь Буддын шашинтан байна. Мөн 15-19 насны нийт шашинтны 1.7 хувь нь Христийн шашинтан байхад 60, түүнээс дээш насанд 3.6 хувь болж өсч байна.

ХҮСНЭГТ 3.9. АРАВ БА ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ШАШИН ШҮТДЭГ ХҮН АМ, ШАШНЫ ТӨРӨЛ, НАСНЫ БҮЛЭГ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН


Насны бүлэг	Шашинтан	Будда	Христ	Ислам	Бөө	Бусад
БҮГД	100	100	100	100	100	100
15-19	9.1	9.1	11.4	0.0	9.5	0.0
20-29	19.7	19.5	14.3	0.0	38.1	0.0
30-39	19.8	19.8	14.3	100.0	23.8	0.0
40-49	19.7	19.8	20.0	0.0	16.7	0.0
50-59	16.0	16.2	5.7	0.0	11.9	100.0
60-69	9.4	9.3	25.7	0.0	0.0	0.0
70+	6.2	6.3	8.6	0.0	0.0	0.0

Арван тав, түүнээс дээш настай Буддын шашинтан хүмүүсийн 19.8 хувийг 30-39 настай хүмүүс, 19.5 хувийг 20-29 настай хүмүүс, 19.7 хувийг 40-49 настай хүмүүс эзэлж байхад, Христ шүтдэг хүмүүсээс 25.7 хувийг 40-49 насныхан, 14.3 хувийг 20-29 насныхан, 20.6 хувийг 20-39 насныхан, 11.4 хувийг нь 15-19 насны залуучууд эзэлж байна. Харин Бөөгийн шашин шүтдэг хүмүүсийн 38.1 хувийг 20-29 настай хүмүүс, 23.8 хувийг 30-39 настай хүмүүс эзэлж байна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ХҮН АМЫН СУУРЬШИЛ, НЯГТРАЛ

ХОТ, СУУРИНД
АМЬДАРДАГ ХҮН АМ



ХӨДӨӨ АМЬДАРДАГ
ХҮН АМ




ХҮН АМЫН СУУРЬШИЛ

Сумдын нутаг дэвсгэрийн хэмжээ харилцан адилгүй, байгалийн баялаг сумдын нутаг дэвсгэрт жигд бус тархсан, уур амьсгал газарзүйн бүсүүдэд ялгаатай, эрс тэс байдаг зэргээс хамааран сумдын хүн амын суурьшил, нягтрал, хөгжлийн түвшин өөр өөр байгаа нь зүй ёсны асуудал билээ. Хүн амын суурьшлыг хот, хөдөөгөөр тодорхойлох нь тухайн нутаг дэвсгэрийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг гүнзгийрүүлэн судалж, орон нутгийн онцлогт тохирсон бодлого боловсруулах үндэс болно.

Дундговь аймгийн нийт хүн амын 26.5 хувь буюу 12.4 мянган хүн аймгийн төвдөө, 73.5 хувь нь буюу 34.3 мянган хүн хөдөөд амьдарч байна.

Монгол Улсын нийт хүн амд Дундговь аймгийн хүн амын эзлэх хувь 2010 онтой харьцуулахад ижил түвшинд буюу 1.5 хувь байна.

ЗУРАГ 4.1 ХҮН АМЫН ТОО, СУМДААР 2020 ОН



ХҮСНЭГТ 4.1. ХОТ, ХӨДӨӨГИЙН ХҮН АМ, НИЙТ ХҮН АМД ЭЗЛЭХ ХУВЬ, 2020 ОН

Байршил	Аймгийн хувьд		Аймгуудын дундаж	
	Хүн ам /мян.хүн/	Эзлэх хувь	Хүн ам /мян.хүн/	Эзлэх хувь
Хот	12.4	26.5	33.4	40.5
Хөдөө	34.3	73.5	49.0	59.5

Дундговь аймаг 2010 онд засаг захиргааны хувьд 15 сум, 66 багаас бүрдэж байсан бол 2020 онд 15 сум, 68 багтай болсон байна.

ХҮСНЭГТ 4.2. ХҮН АМ, БАГИЙН ТОО, СУМДААР, 2010, 2020 ОН

Сум	Багийн тоо		Хүн ам	
	2010	2020	2010	2020
Нийт	66	68	38 543	46 698
Дэлгэрцогт	3	3	1 166	1 639
Дэрэн	4	4	1 481	2 142
Говь-Угтаал	3	4	1 312	1 540
Цагаандэлгэр	4	4	674	1 038
Баянжаргалан	3	3	1 135	1 301
Өндөршил	2	3	1 433	1 406
Гурвансайхан	4	4	1 676	2 133
Өлзийт	6	6	1 757	2 373
Хулд	4	4	1 623	2 383
Луус	3	3	1 369	1 883
Дэлгэрхангай	4	4	1 894	2 301
Сайхан-Овоо	4	4	1 904	2 131
Эрдэнэдалай	7	7	5 097	5 832
Сайнцагаан	9	9	13 664	15 764
Адаацаг	5	5	2 358	2 832

2020 онд Дундговь аймгийн нийт хүн амын 33.8 хувь нь Сайнцагаан суманд, 12.5 хувь нь Эрдэнэдалай суманд оршин сууж байгаа буюу бараг тал орчим хувь нь энэ хоёр суманд суурьшиж байна.

Аймгийн төвийн боловсрол, эрүүл мэнд, ажлын байр, худалдаа, үйлчилгээ, дэд бүтэц зэрэг нийгмийн салбарын хөгжил хөдөөгөөс илүү байгаа нь шилжин ирэгчдийг татаж байна. Манай аймгийн хувьд хөдөөгийн хүн амын эзлэх хувийн жин 70-аас илүү хувийг эзэлж байгаа нь иргэд мал аж ахуйг түшиглэн амьдрал ахуйгаа залгуулж байгаатай холбоотой юм.

ХҮСНЭГТ 4.3 ХҮН АМЫН ТОО, СУМДААР, ӨСӨЛТ, ХУВИАР, 2010, 2020 ОН

Сум	Хүн ам		2020 2010%	Дүнд эзлэх хувь	
	2010	2020		2010	2020
БҮГД	38 543	46 698	21.2	100.0	100.0
Дэлгэрцогт	1 166	1 639	40.6	3.0	3.5
Дэрэн	1 481	2 142	44.6	3.8	4.6
Говь-Угтаал	1 312	1 540	17.4	3.4	3.3
Цагаандэлгэр	674	1 038	54.0	1.7	2.2
Баянжаргалан	1 135	1 301	14.6	2.9	2.8
Өндөршил	1 433	1 406	-1.9	3.7	3.0
Гурвансайхан	1 676	2 133	27.3	4.3	4.6
Өлзийт	1 757	2 373	35.1	4.6	5.1
Хулд	1 623	2 383	46.8	4.2	5.1
Луус	1 369	1 883	37.5	3.6	4.0
Дэлгэрхангай	1 894	2 301	21.5	4.9	4.9
Сайхан-Овоо	1 904	2 131	11.9	4.9	4.6
Эрдэнэдалай	5 097	5 832	14.4	13.2	12.5

Сайнцагаан	13 664	15 764	15.4	35.5	33.8
Адаацаг	2 358	2 832	20.1	6.1	6.1

Хүн амын суурьшлыг сумдаар авч үзэхэд 2010 оноос хойш Өндөршил сумаас бусад бүх сумдын хүн ам 11.9-54.0 хувиар өссөн байна. Хүн амын тоо нь 2010 оныхоос Өндөршил сум буурсан үзүүлэлттэй байна. Аймгийн хүн амын дундаж өсөлт 21.2 хувьтай байхад Дэлгэрцогт, Дэрэн, Цагаандэлгэр, Гурвансайхан, Өлзийт, Хулд, Луус, Дэлгэрхангай сумдууд дунджаас дээгүүр байна. Аймгийн хэмжээнд 2000-аас дээш хүн амтай сум 6, 2500-аас дээш хүн амтай сум 3 байгаа нь харьцангуй өсөлттэй байна.

ХҮН АМЫН НЯГТРАЛ

Улс төр соёл, түүх, засаг захиргаа, цаг агаар, газарзүй зэрэг олон хүчин зүйлс хүн амын суурьшил, нягтралд нөлөөлдөг. Сүүлийн 10 жилд аймгийн хүн амын нягтралд хамгийн их нөлөөлсөн хүчин зүйлд хүн амын шилжих хөдөлгөөн орж байна.

Дундговь аймгийн хувьд 2010 онд 1 километр квадрат нутаг дэвсгэрт 0.5 хүн ногдож байсан бол 2020 онд 0.6 болж, 0.1 пунктээр өссөн байна. Дундговь аймгийг бусад аймгуудтай харьцуулахад хүн амын нягтрал хамгийн бага Өмнөговь, Говь-Алтай аймгийн дараагаар орж байна. Энэ нь улсын дунджаас 1.4 пунктээр бага үзүүлэлт юм.

ХҮСНЭГТ 4.4. ХҮН АМЫН ТОО, НЯГТРАЛ, СУМААР, ХУВИАР, 2010, 2020 ОН

Сумд	2010 он			2020 он		
	Мянган хүн	Дүнд эзлэх хувь	Хүн/км ²	Мянган хүн	Дүнд эзлэх хувь	Хүн/км ²
БҮГД	38 543	100.0	0.5	46 698	100.0	0.6
Дэлгэрцогт	1 166	3.0	0.5	1 639	3.5	0.7
Дэрэн	1 481	3.8	0.4	2 142	4.6	0.6
Говь-Угтаал	1312	3.4	0.5	1 540	3.3	0.6
Цагаандэлгэр	674	1.7	0.2	1 038	2.2	0.3
Баянжаргалан	1 135	2.9	0.4	1 301	2.8	0.4
Өндөршил	1 433	3.7	0.3	1 406	3.0	0.3
Гурвансайхан	1 676	4.3	0.3	2 133	4.6	0.4
Өлзийт	1 757	4.6	0.1	2 373	5.1	0.2
Хулд	1 623	4.2	0.3	2 383	5.1	0.4
Луус	1 369	3.6	0.4	1 883	4.0	0.6
Дэлгэрхангай	1 894	4.9	0.3	2 301	4.9	0.4
Сайхан-Овоо	1 904	4.9	0.5	2 131	4.6	0.5
Эрдэнэдалай	5 097	13.2	0.7	5 832	12.5	0.8
Сайнцагаан	13 664	35.5	4.0	15 764	33.8	4.6
Адаацаг	2 358	6.1	0.7	2 832	6.1	0.9

Хүн амын нягтралыг сумдаар харахад Сайнцагаан суманд хамгийн өндөр буюу 4.6, Эрдэнэдалай, Адаацаг, Дэлгэрцогт, Сайхан-Овоо, Дэрэн, Говь-Угтаал, Луус сумдад 0.5-0.9, бусад сумдад 0.5-аас бага нягтралтай байна.

ЗУРАГ 4.2. ХҮН АМЫН НЯГТРАЛ, СУМДААР, 2020 ОН

